

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТНУУДЫН ОРОН
НУТГИЙН ЗӨВЛӨЛГӨӨН, СУРГАЛТ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТНУУДЫН ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛГӨӨН, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ДҮН

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2008 оны 72 тоот тушаалаар 2009 оныг байгаль хамгаалагчдыг чадавхижуулах жил болгон зарлаж дараах ажлыг эхний хагас жилд багтаан зохион байгуулаад байна.

Энэ хугацаанд 21 аймаг, нийслэлд “Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн”-ийг аймгийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгууллаа.

Зөвлөлгөөнд “Аймгийн байгаль орчны тулгамдсан асуудлууд түүнийг даван туулах арга зам” илтгэлийг аймгийн засаг дарга нар, Байгаль орчны салбарт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны мэдээллийг Байгаль орчин аялал жуулчлалын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар тус тус тавьж хэлэлцүүлээ.

Зөвлөлгөөнөөс зөвлөмж, уриалга, төлөвлөгөө гэсэн гурван үндсэн шийдвэр гаргаж байгаль орчны тулгамдсан асуудлуудыг орон нутгийн хэмжээндээ шийдвэрлэх арга замыг тодорхойллоо.

Зөвлөлгөөний ажиллагаанд 13 аймгийн Засаг дарга, 18 аймгийн Засаг даргын орлогч, тамгын газрын дарга 11 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нар тус тус оролцсон байна. Төв аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар салбарын хэмжээндээ үлгэр жишээ, жишиг байгууллага болох зорилтыг дэвшүүлэв.



Байгаль орчны ажилтнуудын сургалтын ажлыг 16 үндсэн сэдвээр 2 өдөрт багтаан Байгаль орчин аялал жуулчлалын яамны газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчид, цагдаагийн ерөнхий газраас бэлтгэсэн сэдвээр орон нутгийн цагдаагийн хэлтсийн дарга нар хичээл заалаа. Говь-Алтай зэрэг аймагт сумдын хэсгийн төлөөлөгч нарыг сургалтад хамруулсан байна.

8 аймгийн прокурор, шүүхийн ерөнхий шүүгч нар сургалтын ажиллагаанд оролцож Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах арга хэлбэрээ тогтоолоо.

Сургалт зөвлөлгөөний ажиллагаанд оролцсон 2000 шахам хүнд “Байгаль орчны хуулийн эмхэтгэл, дүрэм журмын эмхэтгэл, Байгаль хамгаалагчийн гарын авлага ном тарааж, бүх байгаль хамгаалагчид ажлын цүнх, ажиглалт судалгааны болон ажлын дэвтэр олголоо.

ОРОЛЦОГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Сумын засаг дарга	Байгаль хамгаалагч	Улсын байцаагчид	ТХГН-ийн байгаль хамгаалагч	Холбогдох төрийн болоод төрийн бус байгууллагын ажилтнууд	БҮГД
334	560	360	236	533	2023

Сургалт зөвлөлгөөний ажлыг зохион байгуулахаар Байгаль орчин аялал жуулчлалын яамны ажлын 3 хэсэг давхардсан тоогоор 31 хүн 62 хоног буюу 1922 хүн/хоног орон нутагт ажиллаж 17900 км замыг туулсан тооцоо гарч байна.

Зөвлөлгөөний явцад гарсан 295 асуултад газар дээр хариулт өгч, яам агентлаг, төр засгийн байгууллагуудад хандаж тавьсан 343 санал хүсэлт, шүүмжлэл гаргасныг шийдвэрлэх түвшингээр нь ангилж үзвэл:

№	Шийдвэрлэх түвшин	Санал шүүмжлэлийн тоо
1	Улсын их хуралд	19
2	Засгийн газарт	4
3	Бусад салбарын чиглэлээр гарсан	28
4	Яамны хүрээнд шийдвэрлэх	268
5	Орон нутагт	17
ДҮН		343

Зөвлөлгөөнд оролцогчдоос гаргасан нийт санал хүсэлтийн 29.6 хувийг газар дээр нь шийдвэрлэж хариуг нь өгсөн байна

Байгаль орчны ажилтнуудын аймгийн зөвлөлгөөн, сургалтын үеэр гарсан санал шүүмжлэлийг нэгтгэн газар, хэлтэс, агентлагуудад хүргүүлж, тэдний тус тусын чиглэлээр хийх ажлын чиглэлийг гаргуулан нэгтгэж, 119 асуудал бүхий төлөвлөгөөний төсөл боловсруулж дахин санал авч 100 асуудалтайгаар энэхүү төлөвлөгөөг боловсруулав.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛГӨӨН ДЭЭР ГАРСАН САНАЛ ШҮҮЖЛЭЛИЙН МӨРӨӨР ЗОХИОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

№	Төлөвлөсөн асуудлыг шийдвэрлэх түвшин	Төлөвлөсөн асуудлын тоо		
		Эхний хувилбар	Сүүлийн хувилбар	
1	Салбар хооронд	21	10	
2	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Зохицуулах	6	6
3		Байгаль хамгаалагчийн талаар	11	11
4		ТХГН-ийн талаар	10	10
5		Ой хамгаалах асуудлаар	16	15
6		Байгалийн ургамал хамгаалах	7	7
7		Усны асуудлаар	14	14
8		Ангийн талаар	12	12
9		БОНБ-ын үнэлгээний талаар	3	3
10		Уул уурхайн талаар	10	9
11		Агаарын бохирдол, хог хаягдал	2	2
12	Аялал жуулчлалын талаар	1	1	
	Яамны хүрээнд шийдвэрлэх асуудлын тоо	92	92	
	Төлөвлөгдсөн бүх асуудал	119	100	



Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн, сургалт _____

Гол гол арга хэмжээнүүдийн зардлыг төлөвлөгөөнд тусгасан бөгөөд нийт дүнгээр авч үзвэл:

ЗАРДЛЫН ТОВЧОО

Он	Улсын төсөв	Байгаль хамгаалах сан	Орон нутгийн төсөв	Төсөл хөтөлбөр	Аялал жуулчлалын сан	Дүн
2009	529.0	488.0		45.0		1062
2010	2377.4	170.0	135.0	385.0	40.0	3107.4
2011	1873.0	25.0	145.0	10.0		2053.0
2012	1785.0	25.0	145.0	10.0		1965.0
Бүгд	6564.4	708	425	450	40.0	8187.4

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 9 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Сургалт, зөвлөлгөөний мөрөөр
зохиох ажлын тухай

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн дээр гарсан санал шүүжлэлийн мөрөөр зохиох ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, шаардагдах зардлыг жил тутмын төсөвт тусгаж, сар, жилээр дүгнэж ажиллахыг газар хэлтэс агентлаг, аймаг, нийслэлийн байгаль орчин аялал жуулчлалын газар, ТХГН-ийн хамгаалалтын захиргааны дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт тус тус үүрэг болгосугай.

3. Орон нутгийн хүрээнд хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавьж дүнг улирал тутам Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга нарт даалгасугай.

САЙД

Л.ГАНСҮХ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛГӨӨН ДЭЭР ГАРСАН САНАЛ ШҮҮЖЛЭЛИЙН МӨРӨӨР ЗОХИОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
Салбар хооронд зохицуулах асуудлууд			
1	Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензийг цуцлах тухай Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газартай зөвшилцөн хамтарсан арга хэмжээ авах	2010	ЭБЭХЯ БОАЖЯ АМГТХЭГ
2	Усгүйгээс ашиглагдахгүй байгаа бэлчээрийн судалгааг аймаг бүрээр хийж, худаг гарган усжуулах тооцоо, үндэслэлийг хамтран боловсруулах	2010	БОАЖЯ, ХХХААЯ
3	Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд чацаргана иж бүрэн боловсруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх төслийн санал боловсруулж, гадаад, дотоодын хандивлагчдад танилцуулах	2009-2010	БОАЖЯ, ХХХААЯ
4	Цөлжилтөд нөлөөлж байгаа ямааны тоо толгойг бууруулах, орлох бизнес /каракуль хурганы арьс бэлтгэх гэх мэт /-ийг бий болгох үндэслэл, саналыг боловсруулж хэрэгжүүлэх	2010-2011	БОАЖЯ, ХХХААЯ
5	Гол мөрөн бохирдуулах, ялангуяа Туул голыг бохирдуулсан байгууллага, иргэдэд экологи-эдийн засгийн үнэлгээгээр нөхөн төлбөр ногдуулан тооцоог барагдуулдаг тогтолцоонд шилжих	2010-2011	БОАЖЯ МХЕГ
6	Экологийн боловсрол олгох асуудлыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт оролцуулах	2010	БОАЖЯ БСШУЯ
7	Байгалийн нөөцийг хамгаалахад цэргийн хүч, боломжийг ашиглах боломжийг судлан шийдвэрлэх	2010	БОАЖЯ БХЯ
8	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензийг цэгцлэх асуудлаар газар, хэлтсүүдийн уулзалт ярилцлага зохион байгуулах	2009	БОАЖЯ ЭБЭХЯ
9	Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензийг цуцлах тухай зөвшилцөн хамтарсан арга хэмжээ авах	2010	БОАЖЯ АМГТХЭГ
10	Ундны усыг зөөлрүүлэх цэнгэгжүүлэх төхөөрөмжийг Баянхонгор аймагт тавиулах	2009	ЗТБХБЯ БОАЖЯ
Яамны түвшинд			
1	Улсын Их Хурал, Засгийн газар, бусад салбарын үйл ажиллагаатай холбогдолтой гарсан санал шүүмжлэлийг холбогдох газруудад хүргүүлж шийдвэрлүүлэх	2009	ТЗУГ

Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн, сургалт

2	Байгаль орчны чиглэлээр гарсан яам, агентлагуудын шийдвэрүүдийг судалж уялдуулан зохицуулах арга хэмжээ авах	2010	ТХСТГ ТЗУГ
3	Байгаль орчны хууль, журам, дүрэмийг нэг мөр, давхардалгүй болгох, цэгцлэх ажлыг зохион байгуулах	2010	ТЗУГ
4	Хууль тогтоомжийн сурталчилгааг орон нутагт өргөжүүлэх хөрөнгийг улсын төсөвт тусгуулах	2010	ТХСТГ
5	БОАЖЯ-аас гарсан эрх зүйн актуудыг салбарын анхан шатны нэгжид шуурхай хүргэх	2010	ТЗУГ БОАЖГ
6	ТХГН-ийн хамгаалалтын захиргаад болон БОАЖГ-азруудын материаллаг баазыг бэхжүүлэх, ажлын байр, компьютер, техник хэрэгслээр хангах	2009	ТХСТГ, ТЗУГ ТХНУГ
Байгаль хамгаалагчдын талаар			
1	Байгаль хамгаалагчдыг холбоожуулах төсөл боловсруулж, G mobile сүлжээг ашиглах боломжийг судлан шийдвэрлэх	2009-2010	ХБОБНГ ТЗУГ
2	Байгаль хамгаалагчдын албан тушаалын зэрэглэлийг дээшлүүлж цалинг нэмэгдэх асуудлыг боловсруулан шийдвэрлэх	2010	ТХСТГ ТЗУГ
3	Байгаль хамгаалагчдын хариуцан ажиллах талбайн нормативыг шинэчлэн байгаль хамгаалагчдыг бүрэн орон тоогоор ажиллуулах	2010	ХБОБНГ ТЗУГ ТХГНУГ
4	Байгаль хамгаалагч бүр хариуцсан газартаа мод үржүүлгийн газартай болох асуудлыг дэс дараатай шийдвэрлэх	2010	ТХГНУГ Ойн газар,
5	Байгаль хамгаалагчдын мэргэшүүлэх сургалтыг жил тутам зохион байгуулж 100-аас доошгүй хүнийг харуулж байх	2010 оноос	ХБОБНГ ТЗУГ ТХГНУГ
6	Байгаль хамгаалагчдын туршлагыг солилцуулах, сэлгүүлэн ажиллах	2010	ТХГНУГ БОАЖГ- ууд
7	Жил тутмын төсөвт байгаль хамгаалагчдын бичиг хэргийн болон бензин шатахууны зардлыг тусгаж байх	2009	ТХСТГ ТХГНУГ
8	Завхан аймгийн Улиастай суманд 1 байгаль хамгаалагчийн орон тоог улсын төсөвт тусгуулах	2010	ТХСТГ
9	Тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах зорилгоор экологийн чиглэлээр их, дээд сургуульд суралцах байгаль хамгаалагчдыг бодлогоор дэмжих	2010	БОАЖГ

Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн, сургалт

10	Байгаль хамгаалагчдыг уналга, дүрэмт хувцас, бие хамгаалах болон аяны хэрэгсэлээр ээлж дараатайгаар хангах арга хэмжээ авч Яамнаас хөрөнгө оруулалтаар олгож байгаа техник хэрэгсэл, дүрэмт хувцасны чанар, эдэлгээнд онцгой анхаарч ажиллана.	2010	ХБОБНГ ТЗУГ ТХГНУГ
11	Байгаль хамгаалагчдын болон санхүүгийн ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ном гарын авлагаар хангах	2009	ТЗУГ ТХГНУГ
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын асуудлаар			
1	ТХГН-ийн удирдлагын газар, ой бүхий ТХГН-ийн хамгаалалтын захиргаадад ойн асуудал эрхэлсэн орон тоо буй болгож, хамгаалалтын захиргаа бүрийг мод үржүүлгийн газартай болгох асуудлыг шийдвэрлэх	2010 оноос	ТХГНУГ Хамгаалалтын захиргаад
2	ТХГН-ийн ойд ой зохион байгуулалтын ажлыг 5 жил тутам, хийж хортон шавьжтай тэмцэх асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэж байх	2010 оноос	ТХСТГ ТХГНУГ Ойн газар
3	ТХГН-т гар аргаар алт олборлох асуудлыг улсын хэмжээнд бүрэн зогсоох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2010	ТХГНУГ
4	УТХГ-ын хамгаалалтын захиргаа, орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах тусгай журам боловсруулан мөрдүүлэх	2010	ТХСТГ ТЗУГ ТХГНУГ
5	Хасагт хайрхан, Шарга, Монгол элсний ТХГН-ыг хамарсан хамгаалалтын захиргаа байгуулж ажиллуулах	2010	ТХГНУГ
6	Орон нутгаас санал болгосон дараах газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх: 1. Заг, Байдрагийн хүрэн бэлчир /Баянхонгор, Заг сум / 2. Суман хайрхан /Говь-Алтай, Эрдэнэ сум/ 3. Онгон таван булаг /Сүхбаатар, Баяндэлгэр сум/ 4. Дархаан уул /Сүхбаатар, Сүхбаатар сум/ 5. Зүүн богд уул /Өвөрхөнгай, Баруун баян улаан сум/ 6. Загийн усны БНГ-ыг өргөтгөж залуу загтай хэсгийг оруулах /Дундговь, Өлзийт/ 7. Улаан тайга /Хөвсгөл, Улаан уул сум/ 8. Бөөнцагаан нуур, Байдрагийн гол /Баянхонгор, Баацагаан сум/ 9. Булган хангай, Мөнх цаст /Увс/	2010 оноос	ТХГНУГ
7	Говийн их ДЦГ-ын Баянхонгорын хэсгийг Их Богдын БЦГ-ын хамгаалалтын захиргаанд харъяалуулах	2010 оноос	ТХГНУГ

8	1.Мөнххайрхан уулын БЦГ-ын хамгаалалтын захиргааг Баян-Өлгий аймгийн Ховд сумд, 2.Цамбагаравын БЦГ-ын хамгаалал-тын захиргааг Ховд аймгийн нутагт шилжүүлэн байршуулах асуудлыг судлан шийдвэрлэх	2010 оноос	ТХГНУГ
9	Харямаатын БНГ-г БЦГ, Булган уул, хорго тэрхийн цагаан нуурыг ДЦГ-ын ангилалд оруулах асуудлыг судлан шийдвэрлэх	2010	ТХГНУГ
10	Говьгурван сайхны болон Онон-Балжийн БЦГ-ын дотоод бүсчлэлийг нутгийн иргэд, байгаль хамгаалагчдын саналыг үндэслэн шинэчлэн боловсруулах асуудлыг судлан шийдвэрлэх	2010	ТХГНУГ
11	Говь-Алтай Завхан аймгийн зарим бүс нутгуудад экологийн төлөв байдлын өөрчлөлтийн судалгаа явуулах эрдэмтдийн баг томилон ажиллуулж хамгаалалтын асуудлыг жич боловсруулан хэрэгжүүлэх.	2009-2010	ХБОБНГ
Ойн асуудлаар			
1	Урд онуудад ногоон хэрэмийн ойн зурвас байгуулсан газруудын хамгаалалтын болон сахиулын зардал, цаашид байнгын хамгаалалтыг шийдвэрлэх	2010	Ойн газар
2	Мод үржүүлгийн газруудын нэгдсэн бүртгэл явуулж тэдгээрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр байгуулах асуудлыг бодлогоор зохицуулан, хүч хөрөнгийг төвлөрүүлэх	2009 оноос	Ойн газар
3	Ойжуулалт, ногоон хэрэмийн ажлын сүүлийн 4-5 жилийн байдалд Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран шалгалт хийх	2009 -2010	Ойн газар
4	Ойжуулалт мод үржүүлгийн ажлын гарын авлага материалуудыг хэвлэн гаргах	2009-2010	Ойн газар
5	Нийслэлийн иргэдийн түлээний хэрэгцээнд шаардагдах 500 мянган м ³ модыг бодлогын түвшинд шийдвэрлэх.	2009	Ойн газар
6	Хөрөө рамуудыг холбогдох газруудтай хамтран шалгаж атестатчилах	2009	Ойн газар
7	Нарантуул, Чингэлтэйн аманд амьд модыг суулгацын зориулалтаар зарж байгаа асуудлыг шалган зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг бодлогын хүрээнд шийдвэрлэх	2009	Ойн газар
8	Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт, Бат-Өлзийт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулж, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажилд дэмжлэг үзүүлэх,	2009-2010	Ойн газар

Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн, сургалт

9	Архангай аймгийн өлзийт суманд гарсан шинэс модны өвчний судалгааг хийж тэмцэх арга хэмжээг төлөвлөх	2009-2010	Ойн газар
10	Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд чацаргана, мод, хүнсний ногоо тарих, иргэдийг хана, араг, хүнсний ногоогоор хангах төсөл боловсруулан гадаад, дотоодын хандавлагчид санал тавьж, бодлогоор дэмжих.	2009-2010	Ойн газар
11	Төв суурин газруудад модны зах ажиллуулах, шатсан модыг цэвэрлэгээний журмаар ашиглуулах асуудлыг судлан боловсруулах	2009-2010	Ойн газар
12	Мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээний загварыг өөрчлөн шинэчлэн хэвлүүлэх	2009	Ойн газар
13	Байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд зориулсан аргагүйн сургалт зохион байгуулах	2009-2010	Ойн газар
14	Импорттоор мод оруулахыг дэмжих эрхгүйн үндэслэлийг боловсронгуй болгох	2010	Ойн газар
15	Ойгоос мод шилжүүлэн суулгах ажлын онол практикийн үндэслэлийг судалж шийдвэрлэх	2010	Ойн газар
16	Харганыг тариалах агротехник боловсруулж, сэргээх арга хэмжээг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх	2010	Ойн газар
Ургамлын асуудлаар			
1	Чихэр өвсний нөөц багасч, элсний нүүдэл нэмэгдэх хандлагатай байгаа тул бэлтгэх асуудлыг тодорхой хугацаагаар хориглох шийдвэр гаргаж мөрдүүлнэ	2010	Ойн газар
2	Чихэр өвсний ашиглалтыг гэрчилгээжүүлэх арга хэмжээ авах	2010	Ойн газар
3	Баянхонгор аймгийн Баацагаан сумын нутагт чихэр өвсний нөөцийн судалгаа хийж холбогдох арга хэмжээ авах	2009	Ойн газар
4	Бэлчээрийн хорт ургамлуудын судалгааг явуулж тархацыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлнэ	2010	Ойн газар
5	Эмийн ховор ургамлуудын тархац нутгийг хамгаалах арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ	2010	Ойн газар
6	Завхан аймгийн Шилүүстэй сумын Хөгжил багийн нутагт ургаж байгаа хортой ургамал болон Дундговь аймгийн Өлзийт суманд ургаж байгаа “Загаслал” ургамлын судалгаа хийх ажлыг зохион байгуулах.	2010	Ойн газар
7	Эмийн ховор ургамлыг түүж устгаж байгаа байдалд хяналт шинжилгээ хийж, түүнийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах	2010	Ойн газар

Усны асуудлаар			
1	Монголын томоохон гол мөрнүүдийн ай савын зөвлөлийг байгуулж нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах арга хэмжээг тусгай төлөвлөгөөгөөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2009 оноос	Усны газар
2	Ус голын ай савд ашигт малтмал хайх олборлох үйл ажиллагааг хориглох эрхзүйн үндсийг бий болгоно	2009 оноос	ТХСТГ Усны газар
3	Тайширын усан цахилгаан станцын гол тэжээгч болох Буянт голыг хамгаалах урсацыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ	2009 оноос	ХБОБНГ Усны газар
4	Дундговь Өлзийт сумын “Баянбулаг” булгийг тохижуулах, хөв байгуулах ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлэх	2009 оноос	Усны газар
5	“Алтанбулаг” худалдаа эдийн засгийн чөлөөт бүсийн Төвлөрсөн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх	2009 оноос	ХБОБНГ Усны газар
6	Үүлэнд зориудаар нөлөөлөх арга хэмжээг Баянхонгорын аймгийн Бууцагаан суманд, явуулын радарыг Завхан, Дундговь аймгуудад ажиллуулах зардлыг улсын төсөвт тусгуулах	2010	ТХСТГ
7	Хашиж хамгаалах шаардлагатай булаг шандны судалгааг сум бүрээр гаргаж дэс дараатай хэрэгжүүлэх	2010 он	Усны газар
8	Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бигэр, Тонхил, Төгрөг сумдууд усан хангамжийн судалгаа хийж, шинээр худаг гаргах, сэргээн засварлах	2011	Усны газар
9	Монгол улсын Засгийн газрын 2005 оны “Төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай” 7 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах замаар аар усны үнийг нэмэх	2010	Усны газар
10	Ширгэж байгаа нуур усыг газар дээр нь судлан, шалтгааныг тодорхойлж сэргээх талаар асуудал боловсруулан шийдвэрлэх	2010	Усны газар
11	Ус ашиглагч бүрийг “Ус ашиглах эрхийн гэрчилгээ”-тэй болгох ажлыг зохион байгуулах	2010	Усны газар
12	Хөв цөөрөм байгуулах талаар туршлага судлах мэргэжлийн туслалцаа үзүүлэх сургалт зохион байгуулах	2009 оноос	Усны газар
13	Орон нутгийн усны тооллогонд зориулан гадаргын усны нэр томъёоны тодорхойлолтыг аймаг орон нутагт хүргүүлэх	2009	Усны газар
14	Гар худаг гаргах ажлыг дэмжих эрхзүйн үндсийг бий болгож урамшуулал олгох	2010	Усны газар
15	Хяргас нуурын экостемийн өөрчлөлтийн судалгааг яаралтай хийх	2009	Усны газар

Ангийн асуудлаар			
1	Гар аргаар ашигт малтмал олборлох болон байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаанд татвар ногдуулах, экологи-эдийн засгийн төлбөр ногдуулах тухай хуулийн төсөл боловсруулах .	2011	ХБОБНГ ТХСТГ
2	Ховд Цэцэг, Алтай, Булган, Үенч сумдын нутгаар тавьж байгаа хөшөөтийн нүүс тээврийн замын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хянан магадлагаа хийж ан амьтан нэвтрэх гарц байгуулах асуудлыг шийдвэрлэх	2009	ХБОБНГ
3	Говь алтай аймгийн Алтай сумд үржиж байгаа Аргалын сүрэгт биотехникийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байх.	2009	ХБОБНГ
4	Аргаль хонь, янгир ямаа, цагаан зээр зэрэг агнуурын амьтдын нөөцийн судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	2009	ТХСТГ, ХБОБНГ
5	Аргаль хонь, янгир ямаа, харсүүлтий зээр зэрэг ховор ан амьтныг агнах тусгай зөвшөөрлийг дуудлагын худалдаагаар олгох түр журам боловсруулж, батлуулах	2009	ТХСТГ, Ажлын хэсэг
6	Тарвага агнахыг зогсоосноос хойш гарсан үр дүнгийн байдалд хяналт шинжилгээ хийж, түүний үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авах	2009	ХБОБНГ
7	Ан амьтныг хамгаалах биотехникийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, бодлогоор дэмжих ажлыг өргөжүүлэх	2009	ТХСТГ
8	Ирвэс хамгаалах төсөл, хөтөлбөрт зарим аймаг, сумдыг хамруулах арга хэмжээ авах		ХБОБНГ
9	Байгалийн төрөл зүйл, ан амьтны тооллогыг шаардлагатай аймаг, орон нутагт мэргэжлийн байгууллагаар хийлгэх, нөөцийг тогтоох	2009	ХБОБНГ
10	Биологийн төрөл зүйл, ялангуяа агнуурын бусад амьтны /алаг даага, тагтаа гэх мэт/ экологи-эдийн засгийн үнэлгээг хийх	2009	ТХСТГ ХБОБНГ
11	Голын халиу, шивэр хандгайг хамгаалах арга хэмжээ авах	2009	ХБОБНГ
12	Айраг, хяргас нууруудын загасны нөөцийг тогтоох	2010	ХБОБНГ
13	Ахуйн зориулалтаар ан амьтан агнах ,барих эрхийн бичгийг орон нутагт хэвлүүлэх явдлыг зогсоож нэгдсэн журмаар хэвлүүлэн нарийн тооцоотой зарцуулах	2010	ХБОБНГ
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ			

Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөлгөөн, сургалт

1	Нүүрс тээвэрлэлтийн үед гарах байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чанарыг сайжруулах цогц арга хэмжээ авах	2009	ХБОБНГ
2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чанарыг сайжруулах, үнэлгээ хийдэг компаниудыг аттестатчилах арга хэмжээ авах	2010	ХБОБНГ
3	Үндсэн ордуудын байгаль орчны үнэлгээний чанарыг сайжруулах хэрэгтэй	2009	ХБОБНГ
Уул уурхай			
1	Гар аргаар ашигт малтмал олборлох болон байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаанд татвар ногдуулах, экологи-эдийн засгийн төлбөр ногдуулах тухай хуулийн төсөл боловсруулах .	2011	ХБОБНГ ТХСТГ
2	Уул уурхайн ашигласан талбайд биологийн нөхөн сэргээлт хийдэг мэргэжлийн байгууллагыг бий болгон ажиллуулах	2009	ХБОБНГ
3	Алтны хайгуул хийх зөвшөөрлөөр олборлолт хийдэг, гар аргаар алт олборлох, алт хайгчийг хууль бусаар ашиглах үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, түүнийг зогссох арга хэмжээ авах	2009	ХБОБНГ
4	Ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход орон нутгийн оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	2009	ТХСТГ ХБОБНГ
5	Нөхөн сэргээлтийн стандартыг ашигт малтмалын төрөл бүрээр /жонш, алт, нүүрс гэх мэт/ болон бүсийн онцлогтой уялдуулан боловсруулан гаргаж мөрдүүлэх	2009	ХБОБНГ
6	Алтны үндсэн орд болон жоншны ордын нөхөн сэргээх аргачлал, стандартыг тус тусад нь боловсруулж мөрдүүлэх арга хэмжээ авах.	2010	ХБОБНГ
7	Ашигт малтмалын дээж авч судлахад ордоос авах дээж сорьцын хэмжээг заасан стандартыг боловсруулж гаргаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах .	2010	ТХСТГ ХБОБНГ
8	Хүдэр зөөж байгаа машинууд говийн эмзэг хөрс замыг цөмлөн бараг жижиг машин далд орохоор хонхойлгож, олон салаа зам гаргаж бйагаад хяналт шинжилгээ хийж, хөрс хамгаалах арга хэмжээ авах.	2009	ХБОБНГ
9	Алтны үндсэн ордын нөхөн сэргээлтийн ажлыг эрс сайжруулах.	2010	ХБОБНГ

10	“Цагаан тоос” хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах	2010	ХБОБНГ
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийн бичгийн талаар тодорхой шийдвэр гаргах	2010	ХБОБНГ
Агаарын бохирдол хог хаягдал			
1	Агаарын бохирдлыг бууруулахын тулд гэрийг цахилгаанаар халаах утаагүй халаалтын технологийг судалж, дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах	2009	ХБОБНГ
2	Ландфилийн аргаар хог хаягдлын цэгийг аймгуудын төвд байгуулж дуусган, сумдад байгуулах ажлыг ээлж дараатай эхлүүлэх арга хэмжээ авах.	2009	ХБОБНГ
Аялал жуулчлалын талаар			
1	Алтай таван богд, Отгонтэнгэр, Завхан гол, Монгол элс орчмоор аялал жуулчлал хөгжүүлэх асуудлыг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2009	АЖГ

Байгаль орчны ажилтнуудын аймгийн зөвлөлгөөн, сургалтын үеэр гарсан санал шүүмжлэлийг нэгтгэн газар, хэлтэс, агентлагуудад хүргүүлж, тэдний тус тусын чиглэлээр хийх ажлын чиглэлийг гаргуулан нэгтгэж. 119 асуудал бүхий төлөвлөгөөний төсөл боловсруулж дахин санал авч 106 асуудалтайгаар энэхүү төлөвлөгөөг боловсруулав.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР